



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд  
хийсэн нийцлийн аудитын тайлан/ҮАГ-НАГ/2017/07-НА/



*Аймгийн хэмжээнд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн  
хэрэгжилт хангалтгүй байна.*

2017 он

**АГУУЛГА**

	Товчилсон үгс	4
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, үндсэн мэдээлэл	5-7
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	<b>Бүлэг 1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулах ажил хангалтгүй байна.</b>	
Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа	1.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөгүй ажиллажээ.	8
Аудитын менежер Х.Наранцацрал	1.2 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахдаа нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, зорилго зорилтын уялдааг тодорхойлох, бодлогын хувилбаруудыг боловсруулах ажил хийгдээгүй байна.	9
Ахлах аудитор Д.Ихбаяр	1.3 Бодлогын баримт бичгийн төслийн хувилбарууд боловсруулагдаагүй тул нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийгдээгүй, төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн гэж тайлагнасан боловч нотлох баримтгүй байна.	9-10
Аудитор Т.Оюун-Эрдэнэ	1.4 Бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгасан боловч хууль журамд бүрэн нийцэхгүй байна.	10-11
<b>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592225 дугаарын утсаар харилцана уу.</b>	1.6 “Шинээр боловсруулах дэд хөтөлбөр”-ийн жагсаалтыг боловсруулж батлуулаагүй байна.	12
Уг тайланг YAГ-ын вэб сайтаас үзнэ үү.	<b>Бүлэг 2 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журмын дагуу тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажил хангалтгүй байна.</b>	
<a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	2.1 Үндэсний хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичгийн тайланг хугацаанд нь ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	12-13
Хаяг: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 2 давхар	2.2. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, ЗГХЭГ-т хүргүүлээгүй байна.	13-16
<b>2017 оны 12 дугаар сар</b>	2.3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.	16-17

	<b>Бүлэг 3 Сумдад хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажил хангалтгүй байна.</b>	
	3.1 Сумдад хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажил хангалтгүй байна.	17-18
	Дүгнэлт	19
	Зөвлөмж	20
	Шалгагдагч байгууллагаас ирсэн санал, тайлбар	21
	Аудитын газрын тайлбар	22
	Тайлан баталгаажуулах тушаал	23-25
	Тайлангийн хавсралтууд	26-28

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ХБТТ</b>	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>ХОХБТ</b>	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт
<b>ОХУ</b>	Оросын холбооны улс
<b>БНХАУ</b>	Бүгд найрамдах хятад ард улс
<b>БНСУ</b>	Бүгд найрамдах солонгос улс
<b>ЗГХЭГ</b>	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
<b>ҮАБЗ</b>	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл

---

## **АУДИТЫН НЭР: “ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”**

**АУДИТЫН КОД: ҮАГ-НАГ/2017/НА-07**

### **АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:**

---

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий аудиторт Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### **НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗОРИЛТ**

---

Хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх үүрэг хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн эсэхийг шалгахад аудитын зорилт чиглэгдсэн.

### **ДЭД ЗОРИЛТ**

---

- Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан эсэх;
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх;
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;

“Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийх нийцлийн аудитын асуудлын шинжилгээнд аймагт хамааралгүй дэд асуултыг хасаж, утга санаа давхацсан асуултыг нэгтгэн тайланг бичлээ. Үүнд:

- 1 дүгүүд бүлгээ 1.5 дахь дэд асуулт нь аймагт хамааралгүй тул хассан.
- 3 дугаар бүлгээ 3.2 дахь дэд асуулт нь 2 дугаар бүлгийн 2.3 дахь дэд асуулттай давхцаж байгаа тул 2.3 дахь дэд асуулттай нэгтгэсэн.

## **АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

---

Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөж эхэлсэн 2016 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хойш боловсруулж баталж, хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний харьяа агентлаг, хэлтэс, Засаг даргын Тамгын газрыг хамрууллаа.

## **АУДИТЫН АРГА ЗҮЙ**

---

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4100 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлав.

Аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалгах, судалгаа авах, мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгах арга зүйг ашиглалаа.

АДБОУС, Төрийн хяналт шалгалтын стандартад заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

## **АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

---

Дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Засгийн газрын тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”;
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Бусад хууль тогтоомж;
- Аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэр, журмууд, аймгийн Засаг даргын шийдвэрүүдийг шалгуур болгон ашиглав.

## **АУДИТЫН ХУГАЦАА, БАГИЙН БҮРЭЛДХҮҮН**

---

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг 2017 оны 10 дугаар сарын 24 өдрөөс эхлэн 12 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл хугацаанд тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны

чанарын хяналтыг хэрэгжүүлж, аёёао аудитор Д.Ихбаяр, аудитор Т.Оюун-Эрдэнэ  
í àð òèéæ ãéóúðäüëúú.

## **АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАГДАХ МЭДЭЭЛЭЛ**

Аудитын тайлангийн нэгдүгээр бүлэгт хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулан баталсан эсэх, хоёр дугаар бүлэгт хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх, гуравдугаар бүлэгт хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх талаар тусгаж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

## **АУДИТЫН ЯВЦАД ТУЛГАРСАН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ**

Аудитын явцад зарим сумдын ЗДТГ-ын дарга нар мэдээ, судалгаа, баримт материалыг шаардсан хугацаанд ирүүлээгүй, ирүүлсэн зарим мэдээлэл нь шаардлага хангахгүй байсан зэргээс аудитын хөтөлбөрийн хугацаа алдагдахад хүргэж байлаа.

## **ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын хөгжлийн баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн зорилт чиглэгдсэн байна.

Энэхүү хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12-т зааснаар “Хөгжлийн бодлогын баримт бичиг”-ийг “үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан энэ хуулийн 4.1.1-4.1.11-д заасан баримт бичиг” гэж тодорхойлж өгсөн байна.

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газраас авсан судалгааны дүнг нэгтгэхэд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш аймгийн хэмжээнд 30 бодлогын баримт бичиг, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан байна.

**БҮЛЭГ 1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулах ажил хангалтгүй байна.**

**1.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөгүй ажиллажээ.**

Дундговь аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг /2012-2031/ 2012 онд, сумдын хөгжлийн цогц төлөвлөгөөг /хөгжлийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөө, хөгжлийн стратеги төлөвлөгөө/ Говь-Угтаал, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдаас бусад сумд 2009-2014 онуудад боловруулан гаргаж, тухайн шатны ИТХ-аараа батлуулан мөрдөж байна.

Аймаг, сумын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг “Мерси кор” олон улсын байгууллагын “Хөдөөгийн агробизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд тус байгууллагын арга зүй, зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулсан байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2<sup>1</sup>, ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 14<sup>2</sup> дэх заалттай нийцэж байна.

Аймаг, сумдын Засаг дарга нар 2016-2020 онд хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж батлуулсан боловч түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын төслийг боловсруулаагүй байгаа нь ХБТТ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2<sup>3</sup> дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Мөн аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг нь төсөл боловсруулах төлөвлөгөө гаргаж ажилласан талаарх нотлох баримтыг аудитын явцад ирүүлээгүй. Энэ нь ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 13<sup>4</sup>, 13.1<sup>5</sup>, 13.2<sup>6</sup>, 17<sup>7</sup>-дахь заалтуудыг биелүүлээгүй байна.

Баянжаргалан, Өлзийт сумд 2016-2020 онд хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ боловсруулж батлуулаагүй байна. Энэ нь орон нутгийн сонгуулийн

<sup>1</sup> Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулахдаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоодыг оролцуулан зохион байгуулж болно

<sup>2</sup> Захиргааны байгууллага Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.2, 6.3-т заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, бодлогын хувилбарыг боловсруулах ажлыг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаар гүйцэтгүүлнэ.

<sup>3</sup> Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

<sup>4</sup> Засаг дарга нь дараах төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлаг, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаач, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан байгуулж, удирдамжаар ханган, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

<sup>5</sup> аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт;

<sup>6</sup> дэд хөтөлбөр.

<sup>7</sup> Энэ журмын 12, 13-т заасан Ажлын хэсэг нь төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.



санал хураалт хүчингүй болж дахин санал хураалт явагдах болсон, сумын Засаг даргын томилгооны асуудал маргаантай байгаа зэргээс шалтгаалсан байна.

## **1.2 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахдаа нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, зорилго зорилтын уялдааг тодорхойлох, бодлогын хувилбаруудыг боловсруулах ажил хийгдээгүй байна.**

Аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө /2012-2031/, сумдын хөгжлийн цогц төлөвлөгөөнд үндэслэн боловсруулжээ.

2017 онд аймагт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 15 дэд хөтөлбөр /үргэлжлүүлэн хэрэгжүүлэх/ байгаа бөгөөд “**шинээр боловсруулах**” дэд хөтөлбөрийг боловсруулах, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, зорилго зорилтын уялдааг тодорхойлж бодлогын хувилбаруудыг боловсруулах ажил хийгдээгүй нь ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 17<sup>8</sup>, 20<sup>9</sup>, 46<sup>10</sup> дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. (Хавсралт:№1,2)

Аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө /2012-2031/, сумдын хөгжлийн цогц төлөвлөгөөг “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Дундговь 2020 он хүртэлх хөгжлийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль”-иудыг удирдлага болгон боловсруулсан байна.

Дээрх бодлогын баримт бичгийг боловсруулахдаа эдийн засаг, нийгэм, эсхүл тодорхой зорилтот бүлэгт урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх хүндрэл, бэрхшээлийг мэдэрч, тулгамдаж буй асуудлыг судалж тодорхойлон, баримт бичигтээ тусгасан байна.

## **1.3 Бодлогын баримт бичгийн төслийн хувилбарууд боловсруулагдаагүй тул нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийгдээгүй, төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн гэж тайлагнасан боловч нотлох баримтгүй байна.**

Аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө /2012-2031/, сумдын хөгжлийн цогц төсөл болон “**шинээр боловсруулах**” дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хүрээнд бодлогын хувилбарууд боловсруулагдаагүй тул нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийгдээгүй байна. Энэ нь ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 18.4<sup>11</sup> дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

<sup>8</sup> Энэ журмын 12, 13-т заасан Ажлын хэсэг нь төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.

<sup>9</sup> Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхдээ тухайн бодлогын баримт бичигт тусган шийдвэрлэх эдийн засаг, нийгэм, эсхүл тодорхой зорилтот бүлэгт урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх хүндрэл, бэрхшээлийг мэдэрч, асуудлыг судалж тодорхойлно. Энэхүү судалгаанд өмнө нь уг асуудлаар хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, статистик судалгаа, түүвэр судалгаа, олон нийтийн зүгээс давтагдан гарч байгаа санал, шүүмжлэл зэргийг ашиглана.

<sup>10</sup> Шинээр боловсруулах дэд хөтөлбөрийн төслийг Засаг дарга боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.

<sup>11</sup> бодлогын хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх;

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсээс “Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөний /2012-2031/ төслийг тухай үед олон нийтээр хэлэлцүүлэн саналыг тусгасан.” гэсэн тайлбарыг өгсөн боловч нотлох баримт материал байхгүй байна”.

Тус стратеги төлөвлөгөөнд “Нийт 18 төрлийн 59 удаагийн үйл ажиллагаанд 3945 хүн хамрагдаж санал бодол, байр сууриа илэрхийлсэн байна.” гэж тэмдэглэсэн байв.

Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн хувьд иргэний нийгмийн байгууллагууд иргэдийн саналыг тусгасан гэж хөтөлбөртөө бичсэн боловч иргэдийн саналыг авсан, хэлэлцүүлэг зохион байгуулсан нотлох баримтыг аудитын явцад ирүүлсэнгүй.

#### **1.4 Бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгасан боловч хууль журамд бүрэн нийцэхгүй байна.**

Аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө /2012-2031/, сумдын хөгжлийн цогц төлөвлөгөө нь ХБТТ хууль гарахаас өмнө боловсруулагдсан боловч ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 52<sup>12</sup>, 52.1<sup>13</sup>, 52.2<sup>14</sup>, 52.3<sup>15</sup>, 52.4<sup>16</sup>, 52.5<sup>17</sup>, 52.6<sup>18</sup> дахь заалтуудын хүрээнд боловсруулжээ.

Гэсэн хэдий ч бодлогын баримт бичгийн зарим нэр томъёо болон агуулга нь ХБТТ хуулийн 6.3.3<sup>19</sup>, ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 11<sup>20</sup> дүгээр зүйлийн 52-60.2 дахь заалтуудтай бүрэн нийцэхгүй байгаа тул дахин хянаж, хууль журамд нийцүүлэн ажиллах нь зүйтэй байна. Тухайлбал:

- Хөгжлийн бодлогын баримт бичгийн нэр томъёог хуульд нийцүүлэх;
- Шалгуур үзүүлэлтэд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан чанарын болон тоон үзүүлэлтүүдийг тусгаж өгөх;
- Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүний нэр томъёог журамд нийцүүлэх гэх мэт

ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 61<sup>21</sup>-д заасан ерөнхий бүтэц агуулгыг аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн бүтэц, агуулгатай харьцуулж үзэхэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний бүлэг тусгагдаагүй байлаа. /Хүснэгт №1/

<sup>12</sup> Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.3, 6.4.3-т заасан төсөл дараах ерөнхий бүтэц, агуулгатай байна.

<sup>13</sup> нэгдүгээр бүлэг. Ерөнхий мэдээлэл;

<sup>14</sup> хоёрдугаар бүлэг. Бодлогын зорилго, зорилт;

<sup>15</sup> гуравдугаар бүлэг. Бодлогын хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа;

<sup>16</sup> дөрөвдүгээр бүлэг. Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт;

<sup>17</sup> тавдугаар бүлэг. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр;

<sup>18</sup> зургаадугаар бүлэг. Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө.

<sup>19</sup> аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт.

<sup>20</sup> Төслийн бүтэц, агуулга

<sup>21</sup> Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл дараах ерөнхий бүтэц, агуулгатай байж болно.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн  
төслийн ерөнхий бүтэц, агуулгын харьцуулалт

Хүснэгт № 1

№	Бүлэг	ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан журамд заасан үйл ажиллагааны хөтөлбөрийн ерөнхий бүтэц агуулга	Аймаг, сумын Засаг даргын боловсруулсан үйл ажиллагааны хөтөлбөрийн ерөнхий бүтэц агуулга
1	2	3	4
1	Нэг дүгээр бүлэг	Ерөнхий мэдээлэл	Засаглалын хүрээнд
2	Хоёр дугаар бүлэг	Эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд	Эдийн засгийн хүрээнд
3	Гурав дугаар бүлэг	Нийгмийн хөгжлийн бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд	Нийгмийн бодлогын хүрээнд
4	Дөрөв дүгээр бүлэг	Байгаль орчны бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд	Хүнс, хөдөө, аж ахуйн үйлдвэрлэлийн хүрээнд
5	Тав дугаар бүлэг	Засаглалын бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд	Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн хүрээнд
6	Зургаа дугаар бүлэг	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ	Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын хүрээнд

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу боловсруулан тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулсан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй 2 арга хэмжээг /1.1.15. ОХУ, БНХАУ, БНСУ, Чех улстай тогтоосон гадаад харилцааг бүх чиглэлээр өргөжүүлнэ, 1.1.16. Аймаг орон нутгаа гадаадын улс орнуудад таниулах үйл ажиллагааг эрчимжүүлж Ази, Европын зарим улс орнуудтай шинээр харилцаа холбоо тогтоон хамтран ажиллана./ төлөвлөсөн байна. Энэ нь ХБТТ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2<sup>22</sup> дахь заалтыг зөрчсөн.

Дээрх зорилтын хүрээнд 2016, 2017 онуудад 6 улс оронтой соёл урлаг, боловсрол, эрүүл мэнд, бизнес, аялал жуулчлал, гадаад үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлүүдээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажлын айлчлал, ажил хэргийн уулзалтууд зохион байгуулан, цаашид гадаадын улс орон, хотуудтай идэвхтэй хамтарч ажиллах талаар санал солилцсон.

Мөн БНСУ-ын Гуянг хоттой хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд ногоон байгууламжийн ажил, Японы “Өвсний үндэс” хөтөлбөрийн санхүүжилтээр 146.0 сая төгрөгийн их засварын ажил, БНХАУ-аас Замын-Үүд суманд суугаа

<sup>22</sup> Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Засаг даргын бүрэн эрхэд үл хамаарах асуудал болон хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй, үндэслэлгүй зорилт, арга хэмжээг тусгахыг хориглоно.

Ерөнхий консулын газрын тусламж дэмжлэгээр 18.0 сая төгрөгийн ногоон байгууламжийн ажлыг хийлгэх зэрэг олон ажлууд шийдвэрлэсэн байна.

### **1.6 “Шинээр боловсруулах дэд хөтөлбөр”-ийн жагсаалтыг боловсруулж батлуулаагүй байна.**

ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 33<sup>23</sup>, 46<sup>24</sup> -д заасны дагуу аймаг хөгжүүлэх хэтийн зорилтын төсөл, шинээр боловсруулах дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан ИТХ-аар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд хүргүүлэхээр заажээ.

Гэвч “шинээр боловсруулах дэд хөтөлбөр”-ийн жагсаалтыг боловсруулж батлуулаагүй, аймгийн хөгжлийн бодлого стратеги төлөвлөгөөг ХБТТ хууль батлагдахаас өмнө боловсруулж батлуулсан байна.

“Шинээр боловсруулах дэд хөтөлбөр”-ийн жагсаалтын төслийг боловсруулж батлуулаагүй нь ХБТТ хуулийн 15.2<sup>25</sup> заалтыг хэрэгжүүлээгүй бөгөөд цаашид жагсаалтын төслийг журмын дагуу боловсруулж, батлуулан, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

**БҮЛЭГ 2. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журмын дагуу тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажил хангалтгүй байна.**

### **2.1 Үндэсний хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичгийн тайланг хугацаанд нь ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс орон нутгийн хэмжээнд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичгээс гадна Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 42 заалт, Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн 89 заалт, Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 заалт, Ерөнхий сайдын захирамжийн 1 заалт, Засгийн газрын тогтоолын 61 заалт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 20 заалт, ҮАБЗ-ийн зөвлөмжийн 1 заалтын хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 90 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна. Тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлжээ.

Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан аймагт холбогдох зорилт арга хэмжээний хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 84.3 хувийн биелэлттэй үнэлсэн байна. Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 40 зорилт, арга хэмжээний хүрээнд дараах хэрэгжилттэй гарчээ.

<sup>23</sup> Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын төслийг Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.

<sup>24</sup> Шинээр боловсруулах дэд хөтөлбөрийн төслийг Засаг дарга боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.

<sup>25</sup> Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

- Бүрэн хэрэгжсэн 19 арга хэмжээ,
- 90 хувийн хэрэгжилттэй 12 арга хэмжээ,
- 70 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ,
- 50 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ,
- 30 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ,
- 10 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ.

Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10.1<sup>26</sup>-д заасны дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн орон нутагт хамаарал бүхий заалтуудын хэрэгжилт болон хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Unelgee.gov.mn мэдээллийн цахим санд хугацаанд нь оруулсан байна.

Тус журмын 10.8-д “Цахим сан нь ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтэд зориулагдсан нээлттэй хэсэгтэй байна” гэж заасан боловч олон нийт Unelgee.gov.mn цахим хуудаснаас хөгжлийн бодлогын баримт бичгийн болон хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй танилцах боломжгүй байна.

## **2.2 Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, ЗГХЭГ-т хүргүүлээгүй байна.**

### ***Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар:***

Дундговь аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөний 4<sup>27</sup> бүлэгт зааснаар 2016 оны эхний улиралд төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шатны хяналт, үнэлгээ хийгдэх байсан боловч хийгдээгүй байна. Энэ нь төлөвлөлт, хяналтын хороо стратеги төлөвлөгөөг хэрэгжиж эхэлснээс хойш жил бүр төлөвлөгөө гаргаагүй, хэрэгжилтийг тооцож, тайлагнаагүй, ХОХБТ-ийн хэлтсээс төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавиагүйгээс шалтгаалсан байна.

ИТХ-ын 2012 оны тогтоолоор “Дундговь аймгийн төлөвлөлт, хяналтын хорооны ажлын журам”-г батлан, хороог Засаг даргаар ахлуулан 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Төлөвлөлт, хяналтын хорооны гишүүдийг томилохдоо нэр заан томилсноос тухай албан хаагч ажлаас гарах, өндөр насны тэтгэвэр тогтоолгон ажлаас чөлөөлөгдөх зэрэг шалтгаанаар хорооны үйл ажиллагаа энэ оныг хүртэл тогтворжоогүй байна.

ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 7 дугаар сарын 37 дугаар тогтоолоор “Төлөвлөлт, хяналтын хороо”-ны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлахдаа албан тушаалаар нь зааж өгсөн нь албан тушаалтан солигдоход тус хорооны

<sup>26</sup> Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээхэд Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг ашиглана

<sup>27</sup> төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шатны үнэлгээг 2016, 2019, 2022 оны эхний улирлуудад тус тус зохион байгуулна. Үе шатны үнэлгээний зэрэгцээ төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын үнэлгээг жил бүрийн эцэст болон тухайн төслийн хэрэгжилтийн дунд хугацаанд хэрэгжүүлж байна

бүрэлдэхүүнийг дахин өөрчлөх шаардлагагүй, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна.

Аймаг хөгжүүлэх хэтийн зорилт буюу стратеги төлөвлөгөөнд ХБТТ хууль хэрэгжиж эхэлснээс хойш хоёр жил тутам буюу 2018 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөжээ.

***Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар:***

Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж хэрэгжилт 89.2 хувьтай үнэлэгдэж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.

Хүснэгтээр зорилт, арга хэмжээ тус бүрийн үнэлгээг харууллаа.

Хүснэгт: № 2

№	Агуулга	Нийт арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжиж байгаа	Нийт хувь
1	Эрүүл чийрэг иргэнтэй Дундговь	66	24	42	89.1
2	Эрдэм боловсролтой иргэнтэй Дундговь	47	23	24	93.6
3	Ажилтай орлоготой иргэдтэй Дундговь	58	31	27	90.9
4	Амар тайван аюулгүй орчинтой Дундговь	42	21	21	81.7
5	Эрх чөлөөтэй иргэдтэй Дундговь	52	18	34	89.6
<b>Нийт</b>		<b>265</b>	<b>117</b>	<b>148</b>	<b>89.2</b>

2016 онд орон нутгийн сонгууль болж, аймгийн Засаг дарга өөрчлөгдөн томилогдсонтой холбоотойгоор ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталжээ.

2017 онд Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 *Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ/* -д заасны дагуу 2018 онд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхээр төлөвлөсөн байна.

***Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар:***

Эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засаг дарга солигдсон учраас өмнөх Засаг даргын хийсэн ажлын үнэлгээг дараагийн Засаг даргад өгөх нь зохимжгүй гэж ИТХ-ын Тэргүүлэгчид үзээд хэлэлцэхгүй гэсэн



шалтгаанаар үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

Мөн ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-д ЗГХЭГ-т хүргүүлэх тайлангийн жагсаалтад эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт байхгүй гэсэн шалтгаанаар ЗГХЭГ-т үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хүргүүлээгүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 /Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ/ гэж заасныг зөрчсөн байна.

Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хагас жилийн хэрэгжилтийг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-аар, жилийн эцсийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-аар тус тус үнэлжээ. График: № 1



Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөнд нийт 130 заалт арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан байна. Арга хэмжээ, зорилтыг графикаар харууллаа.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд эхний 5 сарын байдлаар үнэлгээ хийхэд 61 хувийн биелэлттэй үнэлэгдэж, төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 9 болон 11 дүгээр саруудад “Сонсгол мэдээллийн” үйл ажиллагаа зохион байгуулж “Ажил эрчимжүүлэх” тухай албан бичгээр хэлтэс, агентлагуудад чиглэл өгч ажилласан байна.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 89.8 хувьтай үнэлэгджээ. Арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийн дүнг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт: № 3

№	Агуулга	Нийт арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжиж байгаа	Нийт хувь
1	Засаглалын хүрээнд	25	17	8	89.2
2	Эдийн засгийн хүрээнд	17	15	1	98.1
3	Нийгмийн бодлогын хүрээнд	40	26	14	86.5
4	Хүнс хөдөө аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэлийн хүрээнд	19	16	3	92.0
5	Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн хүрээнд	11	6	4	88.0
6	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хүрээнд	18	9	4	88.4
	<b>Дүн</b>	<b>130</b>	<b>89</b>	<b>34</b>	<b>89.8</b>

Холбогдох хэлтсүүд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэхдээ албан бичгээр баталгаажуулан хүргүүлдэггүй, цахимаар хүргүүлдэг тул хугацаанд нь хүргүүлсэн эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байлаа.

Засаг даргын 2017 оны 12 сарын 11-ний өдрийн 452 дугаар захирамжаар орон нутгийн онцлогт тохируулан “Дундговь аймгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг батлан гаргажээ.

Холбогдох хэлтэс, агентлагаас хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэх хугацааг хууль, журмаар зохицуулагдаагүй учир Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс дотоод журмаараа хуваарийг гарган ажилладаг байна.

**2.3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.**

“Дундговь аймгийн Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг /2012-2031/” 2012 онд баталж, төлөвлөлт хяналтын хороог Засаг даргаар ахлуулан томилсон боловч төлөвлөлт, хяналтын хороо болон ХОХБТ-ийн хэлтсээс тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар ажил зохион байгуулаагүй, биелэлтэд нь хяналт тавиагүй байна. Энэ нь тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4<sup>28</sup> дэх заалтыг зөрчсөн байна.

ХБТТ хууль батлагдахаас өмнө сумдын хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулагдаж батлагдсан бөгөөд хуулийн 14.4. */Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна./* дахь заалт хэрэгжээгүй байна.

<sup>28</sup> Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна



ИТХ нь Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хувьд хэрэгжилтийг өмнөх Засаг дарга солигдсонтой холбогдуулан хэлэлцээгүй нь ХБТТ хуулийн 15 дугаар зүйлийн 15.4<sup>29</sup>, 16 дугаар зүйлийн 16.3<sup>30</sup> дахь заалтуудыг тус тус зөрчжээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, ЗГХЭГ-т хүргүүлээгүй нь тус хуулийн 16.5<sup>31</sup> дахь заалтад заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Аймаг сумын ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж дүгнээгүй байна.

Энэ нь ХБТТ хуулийн 15.4<sup>32</sup>-дэх заалтыг зөрчиж байгаа тул дээрх заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Мөн 2016, 2017 онуудад аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ нь эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг, тухайн жилийн төслийн хамт тухай ИТХ-д өргөн мэдүүлж батлуулсан байна.

Энэ нь ХБТТ хуулийн 16.2<sup>33</sup>, 16.3<sup>34</sup>, 16.4<sup>35</sup>-дэх заалтыг зөрчиж байгаа тул цаашид хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

### **БҮЛЭГ 3. Сумдад хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажил хангалтгүй байна.**

#### **3.1. Сумдад хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажил хангалтгүй байна.**

Аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө /2012-2031/, сумдын хөгжлийн цогц төлөвлөгөөг ном хэлбэрээр хэвлэн олшруулж төрийн байгууллагуудад хүргүүлж, аймгийн хөгжлийн бодлого стратеги төлөвлөгөөг /2012-2031/ [www.mercycorps.org.mn](http://www.mercycorps.org.mn) сайтад байршуулсан байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг [www.dundgovi.khural.mn](http://www.dundgovi.khural.mn), [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn) цахим хуудсуудад байршуулан олон нийтэд ил тод болгож, Засаг даргын мөрийн хөтөлбөрийг жижиг ном хэлбэрээр хэвлэн олшруулж иргэд, төрийн

<sup>29</sup> Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ

<sup>30</sup> Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ/

<sup>31</sup> Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ

<sup>32</sup> Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ.

<sup>33</sup> Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

<sup>34</sup> Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ.

<sup>35</sup> Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна.

байгууллагуудад хүргүүлсэн нь ХБТТ хуулийн 22.1<sup>36</sup> дэх заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Сумдын хувьд Сайнцагаан сумаас бусад сумд Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг цахим хуудсанд байршуулаагүй, батлагдсан үйл ажиллагааны хөтөлбөрөө хэвлэн олшруулж иргэд олон нийтэд сурталчилсан талаарх нотлох баримтыг ирүүлсэнгүй.

---

<sup>36</sup> Батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, хэвлэх, сурталчлах ажлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүн, тайланд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөгүй ажиллажээ.
2. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахдаа нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, зорилго зорилтын уялдааг тодорхойлох, бодлогын хувилбаруудыг боловсруулах ажил хийгдээгүй байна.
3. Бодлогын баримт бичгийн төслийн хувилбарууд боловсруулагдаагүй тул нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийгдээгүй, төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн гэж тайлагнасан боловч нотлох баримтгүй байна.
4. Бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгасан боловч хууль журамд бүрэн нийцэхгүй байна.
5. “Шинээр боловсруулах дэд хөтөлбөр”-ийн жагсаалтыг боловсруулж батлуулаагүй байна.
6. Үндэсний хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичгийн тайланг хугацаанд нь ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.
7. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, ЗГХЭГ-т хүргүүлээгүй байна.
8. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.
9. Сумдад хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажил хангалтгүй байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### Аймаг, сумдын ИТХ-ын даргад

1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэж хэвших
2. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэж хэвших

### Аймаг, сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт:

1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг хууль, журмын дагуу боловсруулан, мөрдөх
2. Аймгийн Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, хууль журамд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийж, төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах
3. Сумдын түвшинд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих, уялдааг хангах үйл ажиллагааг зохион байгуулах
4. Аймаг, сумдын ЗДТГ тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, хуульд заасан хугацаанд ИТХ-д өргөн мэдүүлж хэвших

### ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Д.ИХБАЯР

АУДИТОР

Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ХЯНАСАН : АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ

## ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга болон ажил хариуцсан холбогдох хүмүүст танилцуулж санал тайлбарыг авлаа.



### ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг,  
Утас: 7059-2494, Факс: 7059-2896,  
E-mail: info@dundgovi.gov.mn

2017.12.19 № 81/1232

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

273 тоот албан бичгийн хариу

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас нийцлийн аудит хийгдэж байгаатай холбогдуулан тайлангийн төсөлтэй танилцан санал тайлбарыг хүргүүлж байна.

1. Аймгийн эдийн засаг нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийхэд 88 заалт арга хэмжээний биелэлт 56,4 хувийн биелэлттэй хэрэгжсэн. Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 3-ны 8 дугаар тогтоолоор 2017 оны аймгийн үндсэн чиглэл төлөвлөгөө батлагдсан ба энэ хугацаанаас өмнө ХШҮДАХ-т 2016 оны АНЗНХҮЧ-ийн биелэлт гарч ирээгүй байсан тул үнэлгээ хийж ИТХ-д танилцуулагдаагүй болно.

2. 2017 оны 1-2 дугаар сард сумдын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх 12 үзүүлэлтэд аймгийн үндсэн чиглэл төлөвлөгөөний сумдад хамааралтай заалтын биелэлтийг 1 тусгай шалгуур болгон тусгаж, Засаг даргын захирамжаар батлагдсан ХШҮ-ний ажлын хэсгүүд үнэлгээ хийхэд 15 сумдын ерөнхий үнэлгээгээр 83 хувьтай хэрэгжсэн.

3. 2016 оны ажлыг ЗГ-ын 2013 оны 322-р тогтоолоор батлагдсан Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээний нийтлэг журмын “Эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээлэх, тайлагнах, ХШҮ-ний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх” 4 дүгээр зүйлийн 22 дугаар заалтын дагуу тайланг ЗГХЭГ-т хүргүүлэх төрөлд хамаардаггүй, шинээр батлагдан гарсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуультай хуучин журам нь уялдаагүй ба ХШҮ-ний шинэ журам 2017 оны 3 сарын 15-нд батлагдан гарсан тул АЭЗНХҮЧ-ийн тайлан 2 сарын 20-ны дотор ЗГХЭГ-т явуулаагүй болно.

4. Холбогдох хэлтэс, агентлагаас хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ХШҮДАХ-т ирүүлэх хугацааг 2017 оны 12 сарын 11 –ний 452 дугаар захирамжаар баталсан ХШҮ-ний аймгийн журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргаж ирүүлж байна. Өмнө нь 2017 оны 9 сарын 27-нд ЗДТГ-ын даргаар баталгаажуулсан хуваарийн дагуу ирүүлж байсан болно.

*Д. Цэдэвэрэн*  
Тайланг амжилттай  
*[Signature]*



ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН

0301184

## ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2-т заасны дагуу аудитын тайлангийн төсөлд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

***Дундговь аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын ирүүлсэн санал, тайлбарт өгөх Аудитын газрын тайлбар***

<b><i>Тайлбар</i></b>	Аймгийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн санал тайлбар нь аудитын тайланд бичигдсэн утга санаатай адил агуулгатай байсан тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

## ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2-т заасны дагуу аудитын тайлангийн төсөлд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/29

Мандалговь

Нийцлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.2, 2.4, Нийцлийн аудитын түр журмын 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлан /YAГ-НАГ/2017/07-НА-г баталсугай.
2. "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Нийцлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /С.Сүхбаатар/, Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/ нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 1 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, нийцлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Ихбаяр/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ТӨВСАНАА

D:\office\Tushaal\A4\Tailan bat.docx



Äóí äã âü àéì аадахь Төрийн аyaèèòú í äãçðû í  
тэргүүлэх àòäèòì ðû í 2017 í í û 12 äyгаар ñãðû í  
20 - ны өдрийн А/29 дугаар ðòò ààèû í 1 ä¿ãýð ðããñðãèò

### АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Аудитын код: **ҮАГ-НАГ/2017/07-НА**

Аудитын нэр: **“Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт”**

№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсөн хуулийн заалт	Зөрчлийн дүн сая.төг	Үүнээс				
				Аудитын явцад барагдуулсан	Акт тавигдсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн	Зөвлөмжийн тоо
1	Аймаг сумын ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж дүгнээгүй байна. <b>Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал</b>	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 <i>/Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ./</i> дахь заалт						1
2	Тухай жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнээгүй. <b>Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал</b>	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дүгээр зүйлийн 16.3 <i>/АИргэдийн Төлөөлөгчдийн Хурал эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ./</i> дэх заалт						1



3	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг хууль, журмын дагуу боловсруулаагүй. <b>Аймаг, сумдын Засаг даргын тамгын газар</b>	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 <i>/Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна./</i> дахь заалт							1
4	“Дундговь аймгийн Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг /2012-2031/” 2012 онд баталж, төлөвлөлт хяналтын хороог Засаг даргаар ахлуулан томилсон боловч төлөвлөлт, хяналтын хороо болон ХОХБТ-ийн хэлтсээс тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар ажил зохион байгуулаагүй, биелэлтэд нь хяналт тавиагүй. <b>Аймаг, сумдын Засаг даргын тамгын газар</b>	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 <i>/Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна/</i> дэх заалт							1
5	Сумдын түвшинд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих, уялдааг хангах үйл ажиллагааг зохион байгуулаагүй. <b>Аймаг, сумдын Засаг даргын тамгын газар</b>	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 <i>/Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна/</i> дэх заалт							1
6	Аймаг, сумдын ЗДТГ тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, хуульд заасан хугацаанд ИТХ-д өргөн мэдүүлээгүй. <b>Аймаг, сумдын Засаг даргын тамгын газар</b>	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 <i>/ Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална./</i> дэх заалт							1
<b>Дүн</b>			-	-	-	-			<b>6</b>

## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хавсралт № 1

**ДУНДГОВЬ АЙМАГТ МӨРДӨГДӨЖ БАЙГАА БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА**

№	Сумдын нэрс	Хэтийн болон, дунд хугацааны бодлогын баримт бичиг	Засаг даргын мөрийн хөтөлбөр /2016-2020 он/	Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр	Нийгэм эдийн засгийн хөгжүүлэх үндсэн чиглэл /2017 /
1	Äýëäýðöîî äð	2012 онд батлагдсан /2010-201/	2016 онд батлагдсан	Боловсруулаагүй	2016 онд батлагдсан
2	Äýðýí	2011 онд батлагдсан /2011-2021 /	2017 онд батлагдсан	Боловсруулаагүй	2017 онд батлагдсан
3	Äí äü-Уäðààëë	Байхгүй	2016 онд батлагдсан	Боловсруулаагүй	2016 онд батлагдсан
4	Öàäààí äýëäýð	Байхгүй	2017 онд батлагдсан	Боловсруулаагүй	2017 онд батлагдсан
5	Äàýí äððäàëäí	2012 онд батлагдсан /2012-2024 /		Боловсруулаагүй	
6	Өндөршил	Байхгүй	2017 онд батлагдсан	Боловсруулаагүй	2017 онд батлагдсан
7	Äððäàí ñàëðäàí	2014 онд батлагдсан /2014-2021 /	2017 онд батлагдсан	Боловсруулаагүй	2016 онд батлагдсан
8	<sup>a</sup> ëçëëò	2009 онд батлагдсан /2009-2020 /		Боловсруулаагүй	
9	Öóëä	2011 онд батлагдсан /2011-2021 /	2017 онд батлагдсан	Боловсруулаагүй	2017 онд батлагдсан
10	Ëóóñ	2011 онд батлагдсан /2011-2021 / 2015 онд өрчлөлт оруулсан/	2017 онд батлагдсан	Дэд хөтөлбөр боловсруулсан боловч батлуулаагүй.	2017 онд батлагдсан
11	Äýëäýððäí ääé	2011 онд батлагдсан /2011-2021 /	2016 онд батлагдсан	Боловсруулаагүй	2016 онд батлагдсан
12	Ñàëðäàí -Í äî î	2011 онд батлагдсан /2011-2021 /	2016 онд батлагдсан	Боловсруулаагүй	2016 онд батлагдсан
13	Ýðäýí ýààëäé	Байхгүй	2017 онд батлагдсан	Боловсруулаагүй	2017 онд батлагдсан
14	Адаацаг	2007 онд батлагдсан /2007-2017 /	2017 онд батлагдсан	Боловсруулаагүй	2017 онд батлагдсан
15	Сайнцагаан	2011 онд батлагдсан /2009-2021 /	2016 онд батлагдсан	Боловсруулаагүй	2016 онд батлагдсан
16	Аймаг	2012 онд баталсан	2016 онд батлагдсан	Боловсруулаагүй	2017 онд батлагдсан

Хавсралт № 2

**ДУНДГОВЬ АЙМАГТ 2017 ОНД ХЭРЭГЖИЖ БАЙГАА АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРҮҮД**

№	Хөтөлбөрийн нэр, баталсан он сар дугаар	Хэрэгжих хугацаа	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцах, тайлагнах байгууллага, ажилтан
<b>Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд</b>			
1	“Хүнсний аюулгүй байдал” дэд хөтөлбөр аймгийн Засаг даргын захирамж 2011.11.3 №А/635	2011-2020	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
2	“Ногоон хөгжил Дундговь” хөтөлбөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 17-р тогтоол	2011-2020	ХОХБТХ- Н.Эрдэнэ-Очир, БОАЖГазар- Н.Гантулга
3	“Тэмээ өсгөхөд дэмжлэг үзүүлэх аймгийн хөтөлбөр” аймгийн Засаг даргын захирамж 2013 оны А/476	2013-2021	ХОХБТХ- Н.Эрдэнэ-Очир, ХХААГазар - Б.Мөнхжаргал
4	“Газар тариалангийн талаар баримтлах аймгийн бодлого” аймгийн Засаг даргын 2015.6.11-ний А/235 захирамж	2015-2020	ХОХБТХ- Н.Эрдэнэ-Очир, ХХААГазар - Б.Мөнхжаргал
5	“Залуу малчдыг дэмжих аймгийн дэд хөтөлбөр” Аймгийн ЗД-ын 2017/02/14-ны А/46	2017-2020	ХОХБТХ- Н.Эрдэнэ-Очир, ХХААГазар - Б.Мөнхжаргал
<b>Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд</b>			
6	“Үндэсний бичиг” аймгийн дэд хөтөлбөр аймгийн ИТХТ-ийн тогтоол 2014.11.21 №265	2014-2019	НБХ –Ц.Эрдэнэсүрэн, БСУГ-Ц.Бумангэрэл
7	"Боловсрол хөгжил" аймгийн хөтөлбөр аймгийн Засаг даргын захирамж 2011.12	2011-2021	НБХ –Ц.Эрдэнэсүрэн, БСУГ- Ц.Бумангэрэл
8	Сэтгэцийн эрүүл мэндийн дэд хөтөлбөр аймгийн Засаг даргын захирамж 2010.10.28 А/474	2010-2019	НБХ -Ц.Эрдэнэсүрэн, ЭМГ-Ц.Энхсайхан
9	Хорт хавдраас сэргийлэх хянах дэд хөтөлбөр 2014.12.02. №412	2015-2020	НБХ -Ц.Эрдэнэсүрэн, ЭМГ-Ц.Энхсайхан
10	Вируст гепатитаас сэргийлэх, элэгний эндэгдлийг бууруулах дэд хөтөлбөр 2015.11.16 №448	2016-2025	НБХ -Ц.Эрдэнэсүрэн, ЭМГ-Ц.Энхсайхан
11	“Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” дэд хөтөлбөр 2014.06.20 №а/368	2014-2020	НБХ -Ц.Эрдэнэсүрэн, ЭМГ-Ц.Энхсайхан
12	“Сэтгэцийн эрүүл мэнд” дэд хөтөлбөр 2010.10.28 №А/474	2010-2019	НБХ -Ц.Эрдэнэсүрэн, ЭМГ-Ц.Энхсайхан

13	“Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах” дэд хөтөлбөр 2014.09.16 №А/572	2014-2021	НБХ -Ц.Эрдэнэсүрэн, ЭМГ-Ц.Энхсайхан
<b>Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд</b>			
14	“Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн хөтөлбөр	2015-2018	ХЭЗХэлтэс Б.Түвшинбаяр
15	“Архигүй дундговь” аймгийн хөтөлбөр /хугацаа сунгасан/	2016-2020	ХЭЗХэлтэс Б.Түвшинбаяр